2019 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ТАНИЛЦУУЛГА

2019.06.30 Улаанбаатар хот

*Нэг.**ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДУУДЛАГА, БҮРТГЭГДСЭН ОСОЛ***

Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 36045-г хүлээн авч шийдвэрлэсэн байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын тоо нь өнгөрсөн оны үзүүлэлтээс улсын хэмжээнд 837 нэгжээр буюу 2.3 хувиар, Улаанбаатар хотод 945 нэгжээр буюу 2.3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Зам тээврийн ослын дуудлагын 95.7 хувь нь нийслэлд ирүүлсэн дуудлага мэдээлэл, 4.3 хувь нь орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст ирүүлсэн дуудлага мэдээлэл эзэлсэн байна.

Улсын хэмжээнд 12839 зам тээврийн осол бүртгэгдсэний 11332 буюу 88.3 хувь нь хотод, 11.2 хувь нь орон нутгийн замд бүртгэгдсэн осол байна. Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад хотод 14.8%-р буурч, орон нутагт 10.3 хувиар өсчээ.



Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад: зам тээврийн осол улсын хэмжээнд буурсан ч орон нутагт 10.3 хувиар өссөн байна.



*Хоёр.**ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ***

Улсын хэмжээнд 2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 17666 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 714 буюу 4.0 хувийг эзэлж байна. /хувийн жин өнгөрсөн оныхоос 0.9 хувиар өссөн/



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг улсын хэмжээнд 15.7%, нийслэлд 32.5%, орон нутагт 2.1%-р өсчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 161 хүн нас барж, 587 хүн хүнд, хүндэвтэр гэмтсэн статистик үзүүлэлт гарсан ч бодит нас баралт 243-т хүрсэн.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 714 бүртгэгдсэнээс 367 буюу 51.4% нь хотод, 347 буюу 48.6% нь орон нутагт бүртгэгдсэн байна. Гэмт хэрэг Баян-Өлгий, Баянхонгор, Говь-алтай аймгуудад 2.0-2.1 дахин, Төв 80.0%, Хөвсгөл 54.5%, Орхон 60.0%, Говь-Сүмбэр 50.0%, Булган 44.4%, Архангай 16.7%-р аймгуудад, нийслэлийн дүүргүүдэд 4.6-65.5% хүртэл тус тус

ӨСЧЭЭ. Дархан, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Ховд, Хэнтий аймаг, Багахангай дүүрэгт БУУРСАН үзүүлэлттэй байна.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих /ЭХ 27.1-27.3/ заалтаар 2019 оны эхний хагас жилийн байдлаар 8 гэмт хэрэг үүсгэгдэн шалгагдсан байна.

*Гурав. **ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ***

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 243 хүн амь насаа алдаж /бодит нас баралтын тоо/, 1729 хүн гэмтэж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 13,7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 161 хүн нас барж, 587 хүн гэмтсэн байна.

АМЬ НАСАА АЛДСАН ХҮН:



Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ЭХХШТХуулийн 1.5.1.1 /32.5.1.1/ дэх заалтаар 52 хэрэг хэрэгсэхгүй болж статистик мэдээнээс хасагдсан учир гэмт хэргийн мэдээнд нас барсан хүний тоо 161 хүнээр тусгагдсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2019 оны эхний хагас жилийн байдлаар зам тээврийн ослын улмаас 58 /бодит/, гэмт хэргийн улмаас 43 хүн амь насаа алдсан үзүүлэлт гарч байна.

Зам тээврийн ослын улмаас 243 хүний амь нас хохирсон үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 11.0 хувиар өссөн үзүүлэлт гарч байна.



ӨСӨЛТ, БУУРАЛТыг төв, орон нутгаар авч үзвэл:

ӨССӨН:

- АРХАНГАЙ аймагт 2.3 дахин
- БУЛГАН аймагт 4 дахин
- СҮХБААТАР аймагт 3.3 дахин
- ГОВЬСҮМБЭР аймагт 3 дахин
- СҮХБААТАР дүүрэг 2.3 дахин
- БАГАНУУР дүүрэг 3 дахин

ТӨВ аймагт 21 ослын тохиолдлоос 26 хүн, **СОНГИНОХАЙРХАН** дүүрэгт 17 тохиолдлоос 19 хүний амь нас хохирчээ.

Орон нутагт **19,** хотод **6** хүүхдийн амь нас хохирсон осол бүртгэгдсэн байна.

БУУРСАН:

Амь насаа алдсан хүний үзүүлэлт БАЯНӨЛГИЙ аймагт 50.0%, ДУНДГОВЬ аймаг 25.0%, УВС аймагт 33.3%, ХЭНТИЙ аймаг 30.0%, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Дорнод аймгуудад 7.7-016.7%-иар тус тус буурчээ.

ГЭМТСЭН ХҮН:

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 1729 хүн эрүүл мэндээрээ хохирсоны 587 нь хүнд, хүндэвтэр зэргийн гэмтэл, 1142 нь гэмтэл, бэртэл авсан байна.



Зам тээврийн ослын улмаас гэмтэл авсан хүний 1289 буюу 74.6 хувь нь нийслэлд үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас, 25.4 хувь нь орон нутгийн замд үйлдэгдсэн ослын улмаас гэмтэл, бэртэл авсан байна.



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 243 хүн /бодит/, гэмтсэн 1729 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг авч үзвэл:

<u>Улсын хэмжээнд:</u>

- <u>Явган зорчигч</u> – 67 хүн амь насаа алдаж, 889 гэмтсэн
- **Жолооч** – 95 хүн амь насаа алдаж, 230 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 80 хүн амь насаа алдаж, 568 гэмтсэн
- Дугуйтай хүн – 1 хүн амь насаа алдаж, 42 гэмтсэн



Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан, гэмтэж бэртсэн хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрээс авч үзвэл: Нийслэлд амь насаа алдсан хүний 75.9 хувийг ЯВГАН ЗОРЧИГЧ, орон нутагт тээврийн хэрэгслийн ЖОЛООЧ 49.2 хувийг эзэлсэн байна.

Дөрөв. ***ХҮНИЙ АМЬ НАС ХОХИРСОН ОСОЛ*** */Гэмт хэрэг/*

Зам тээврийн ослын улмаас 2019 оны эхний хагас жилийн байдлаар 224 ослын тохиолдолоос 243 хүний амь нас хохирсон тоон үзүүлэлт гарч байна.



Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад хүний амь нас хохирсон ослын тохиолдол 30 нэгжээр буюу 15.5 хувиар, амь насаа алдсан хүний тоо 27 нэгжээр буюу 12.5 хувиар өсчээ. Амь насаа алдсан хүний 75.0 хувь нь орон нутагт, 25.0 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.



Улсын хэмжээнд 2 ба түүнээс дээш хүний амь нас хохирсон 18 осол бүртгэгдсэн. Үүнээс газар дээрээ 5 хүний амь нас хохирсон 1 осол, 3 хүний амь нас хохирсон 6 осол, газар дээрээ 2 хүний амь нас хохирсон 11 осол тус тус бүртгэгдсэн байна.





Хүний амь нас хохирсон осол 2019 оны эхний хагас жилийн байдлаар 6 дугаар сард хамгийн их бүртгэгдэж, өдрийн цагт хүний амь нас хохирсон ослын 71,4% нь гарчээ.

Хүний амь нас хохирсон осол 06.00-14.00 цагт 110 буюу 29.4 хувь, 14.00-19.00 цагуудад 121 буюу 32.4 хувь, 19.00-22.00 цагуудад 71 буюу 19.0 хувь, 22.00-06.00 цагуудад 72 буюу 19.3 хувь нь тус тус бүртгэгджээ.



Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүний амь нас хохирсон ослын шалтгаан нөхцлөөс харахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос 31.5%, анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан осол 15.2%, хурд хэтрүүлсэнээс 27.4%, явган зорчигчийн буруутай үйлдлээс 11.2% нь тус тус бүртгэгджээ.

Тайлангийн хугацаанд хүний амь нас хохирсон осолд холбогдсон тээврийн хэрэгслийн насжилт, жолооны хүрдний байрлалаар судалгаа хийв.

Автомашины жолооны хүрдний байрлалаас харахад: баруун талдаа жолооны хүрд байрласан автомашин 57.4% нь байхад зүүн талдаа буюу зөв талдаа жолооны хүрд байрлалтай автомашин 42.6%-г эзэлж байна.



Хүрдний байрлал	Тоо	Эзлэх хувь
БАРУУН	74	57.4
ЗҮҮН	55	42.6

Хүний амь нас хохироосон осолд холбогдсон тээврийн хэрэгслийн насжилтын байдлаар судалгаа гаргахад: 15-с дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 52.7%, 10-14 жилийн насжилттай 41 буюу 31.3%, 7-9 жилийн насжилттай 13 буюу 9.9%, 4-6 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 4.6%, 0-3 жилийн насжилттай тээврийн хэрэгсэл 1 буюу 0.8%-г тус тус эзэлсэн байна.

Хүний амь нас хохирсон осолд холбогдсон автомашины төрлөөс харахад: TOYOTA брэндийн PRIUS маркийн автомашин 21.1 хувийг эзэлж байна. Энэ төрлийн автомашин Монгол улсад их бүртгэлтэй ба замын хөдөлгөөнд оролцох нь их байдагтай холбон үзэж болно.

*Тав. **ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ШАЛТГААН***

Улсын хэмжээнд 2019 оны эхний хагас жилд бүртгэгдсэн 12839 зам тээврийн ослын 12561 буюу 97.8 хувь нь жолоочийн буруугаас, 261 буюу 2.1 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, замын нөхцөл байдлаас 17 буюу 0.1 хувь нь бүртгэгджээ.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн 12839 зам тээврийн ослын шалтгаанаас авч үзвэл:

ЖОЛООЧИЙН БУРУУТАЙ ҮЙЛДЭЛ	ЯВГАН ЗОРЧИГЧИЙН БУРУУТАЙ ҮЙЛДЭЛ	ЗАМЫН НӨХЦӨЛ
12561 буюу 97.8%	261 буюу 2.1%	17 буюу 0.1%
❑ Уулзвар гарц нэвтрэх журам – 18.3% ❑ Зай тохируулаагүй 46.9% ❑ Эгнээ байр буруу эзэлсэн 12.4% ❑ Согтуугаар т/х жолоодсон 3.2% ❑ Хурд хэтрүүлсэн 3.1%	Нийт явган зорчигч мөргөсөн осолд явганы өөрийнх нь буруутай үйлдлээс шалтгаалсан осол 26.5% эзэлсэн. ❑ Явган зорчигч буруу 47.1% ❑ Согтуу явган зорчигч 37.9% ❑ Харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд ооролцуулсан 20.1%	ОРОН НУТАГТ 4 ОСОЛ ХОТОД 13 ОСОЛ бүртгэгдсэн. Замын нөхцөлөөс шалтгаалсан осол маш бага үзүүлэлт гарч байгаад анхаарах.

Жолоочийн буруутай үйлдэл дотроос уулзвар, гарц нэвтрэх журам зөрчсөн, зай тохируулаагүй, эгнээ байр буруу эзэлсэн, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, хурд хэтрүүлсэн шалтгаан дийлэнх хувийг эзэлсэн байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан осолд явган зорчигч өртөж хохирсон осолд харьцуулан авч үзвэл өөрсдийнх нь буруутай үйлдлээс шалтгаалсан осол 26.5%-г эзэлжээ.



Согтуугаар үйлдэгдсэн осол Өвөрхангай аймагт давамгайлсан байхад нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт бусад дүүргээс их бүртгэгдсэн байна.

Зургаа. ***ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ХЭЛБЭР***

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 10692 буюу 83.3% нь мөргөлдөх, 982 буюу 7.6% нь явган зорчигч мөргөх, 461 буюу 3.6 хувь нь онхолдох, 492 буюу 3.8 хувь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, орон сууц, шон мөргөсөн/, зорчигч унагах 38, дугуйтай хүн мөргөх 45, мал, амьтан дайрах 55 осол, 74 буюу 0.6 хувь нь бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

№	ХЭЛБЭР	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Мөргөлдөх	10692	83.3	9971	88.0	721	47.8
2	Явган хүн дайрах	982	7.6	852	7.5	130	8.6
3	Үл хөдлөх зүйл мөргөх	492	3.8	386	3.4	106	7.0
4	Онхолдох	461	3.6	51	0.5	410	27.2
5	Мал, амьтан дайрах	55	0.4	10	0.1	45	3.0
6	Зорчигч унагах	38	0.3	16	0.1	22	1.5
7	Дугуйтай хүн мөргөх	45	0.4	35	0.3	10	0.7
8	Бусад	74	0.6	11	0.1	63	4.2

Зам тээврийн осол гарсан хэлбэрээс авч үзвэл: ОНХОЛДОХ хэлбэрээр бүртгэгдсэн ослын 88.9% нь ОРОН НУТАГТ бүртгэгдсэн байхад ЯВГАН ЗОРЧИГЧ мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн ослын 86.8% нь НИЙСЛЭЛД тус тус бүртгэгджээ.